



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/04

Алтанбулаг

Г Нохой устгал зохион байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 32 дугаар зүйлийн 32.1.1, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 385 дугаар тогтоол, сумын Онцгой комиссын 2022 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.ОХУ-д малын гоц халдварт товруудах өвчин гарсантай холбогдуулан хилийн боомт орчмын бүсээр байгаа эзэнгүй нохой устгах ажлыг яаралтай зохион байгуулахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (С.Мөнхзул)-д даалгасугай.

2.Нохой устгалын ажил хийхэд холбогдох зардал, тохижилт үйлчилгээний албаны 65-32 СЭА улсын дугаартай тээврийн хэрэгслийн аккумуляторыг шинэчлэхэд шаардлагатай 430,000 төгрөгийг сумын Онцгой комиссын зардлаас гаргахыг Санхүү албаны дарга (Р.Үнэнбат)-д зөвшөөрсүгэй.

Н.ОТГОНЦОГТ